



МОНГОЛ УЛСАД БАНКНЫ ТОГТОЛЦОО ҮҮСЭН ХӨГЖСӨНИЙ 100 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсэн хөгжсөний түүхэн 100 жилийн ойг тохиолдуулан банк санхүүгийн системийн хөгжил, төв банкны үйл ажиллагааг сурталчлан таниулах хүрээнд энэхүү бүтээлийн уралдааныг зарлаж байна. Бүтээлийн уралдааны зорилго нь эдийн засаг, статистик болон санхүүгийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг судлаач, эрдэмтэд болон оюутнуудыг дэмжих, тэдгээрийн бүтээлийг нийтэд түгээн дэлгэрүүлэх, бодлого боловсруулахад оролцох оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР. СЭДВИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Бизнесийн мөчлөгийг оновчтой тодорхойлох нь
- 2.2 Үндэсний тооцооны систем
- 2.3 Хөрөнгийн урсгалын матриц
- 2.4 Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн шинжилгээ, зөвлөмж
- 2.5 Эдийн засгийн онолын сэтгэлгээ, орчин үеийн дэг сургуулиудын ялгаа, тэдгээрийн түүхэн хувьсал: Монголын эдийн засгийн сэтгэлгээ бүрэлдсэн эсэх
- 2.6 Макро бодлогуудын оновчтой хослол, институцийг тодорхойлох нь
- 2.7 Валютын ханшийн инфляцад шилжих нөлөө, түүний хэрэглээ
- 2.8 Агентын зан төлөвийн өөрчлөлтийн валютын ханшид үзүүлэх нөлөөг түүвэр судалгааны аргаар тодорхойлох нь
- 2.9 Гадаад валютын нөөцийн багцын оновчтой удирдлага, олон улсын туршлага
- 2.10 Монголын эдийн засаг дахь нейтрал хүүний түвшинг үнэлэх нь
- 2.11 Инфляцыг өдөөгч хүчин зүйлс, тэдгээрт үзүүлэх мөнгөний бодлогын оновчтой хариу арга хэмжээг тодорхойлох нь
- 2.12 Нийтийн алба – хувийн секторын цалингийн уялдаа, цалингийн өсөлтийн инфляцад үзүүлэх нөлөө
- 2.13 Төсвийн зардлын бүлгийн инфляц, төлбөрийн тэнцэлд үзүүлэх нөлөөг шинжлэх нь
- 2.14 Засгийн газрын өрийн удирдлага, тогтвортой байдлын шинжилгээ
- 2.15 Төсвийн давамгайлал ба төв банкны хараат бус байдал
- 2.16 Төв банкны хараат бус байдал: Засгийн газар – Төв банк, Улсын Их Хурал – Төв банк хоорондын харилцааг оновчтой тодорхойлох нь

- 2.17 Гадаад худалдаанд нөлөөлөгч эдийн засгийн хүчин зүйлсийн шинжилгээ, зөвлөмж
- 2.18 Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтүүд: Монголын эдийн засгийн хувьд тодорхойлох нь
- 2.19 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох мал аж ахуйн салбарын бодлого, бэлчээрийн хомсдол: Эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцох нь
- 2.20 Уур амьсгалын өөрчлөлт, түүнтэй тэмцэх бодлогын арга хэрэгслийн эдийн засагт үзүүлэх нөлөө
- 2.21 Ногоон, тогтвортой санхүүжилтийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөг тооцох нь
- 2.22 Ногоон, цахим шилжилтийн замын зургийг тодорхойлох нь
- 2.23 Монгол Улсын “цэнхэр эдийн засаг” /blue economy/-ийн хөгжил, тулгамдаж буй асуудлууд
- 2.24 Цалингийн доод хэмжээг оновчтой тогтоох нь: Онол, арга зүйн болон бодлогын асуудлууд
- 2.25 Үндэсний баялгийн сан байгуулах олон улсын туршлага, иргэд, өрхүүдийн баялагтай холбох боломж: Бодлого, стратегийг тодорхойлох нь
- 2.26 Гадаадын хөрөнгө оруулалттай банк дотоодын санхүүгийн зах зээлд нэвтрэх боломж, тулгамдаж буй асуудлууд
- 2.27 Түүвэр судалгааны үр дүн болон микро түвшний өгөгдлийг бодлогын судалгаа, шинжилгээнд ашиглах нь: Эдийн засаг, банкны салбарт их өгөгдөл ашиглах талаарх зөвлөмж
- 2.28 Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө: Жендерийн эдийн засаг
- 2.29 Монгол Улсад газрын реформ хийх онол арга зүй, өнөөгийн хандлага, бодлогын зөвлөмж
- 2.30 Цахим мөнгө, түүний эдийн засаг, санхүүгийн зах зээлд үзүүлэх нөлөө, бодлогын хувьд анхаарах асуудлууд

ГУРАВ. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

3.1 Бүтээлийн агуулгад тавигдах ерөнхий шаардлага:

- Онол, аргазүйн үндэслэлтэй, олон талт, шинэлэг сэтгэлгээгээр хандсан байх
- Шинэлэг, оновчтой санал, санаачилга дэвшүүлсэн байх
- Бодит мэдээлэл ашиглаж, баримтаар баталгаажуулах
- Практик ач холбогдолтой байх
- Тоон болон чанарын шинжилгээний арга хэрэгслүүдийг ашигласан байх
- Бусдын ажлыг хуулбарлаагүй, судалгаанд ашигласан материалыг бүрэн дурдах
- Судалгааны бүтээл нь гарчиг, хураангуй, удиртгал, судалгааны хэсэг, дүгнэлт, ном зүй гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдсэн байх
- Судалгааны нүүр хуудсанд нэр, холбоо барих 2 утасны дугаар, цахим шуудан, ажлын болон сургуулийн нэр, курс, мэргэжил, судалгааны ажлын нэрийг бичих
- Оюутны ангилалд оролцох судалгааны ажлууд заавал удирдагч багштай байх, удирдагч багшийн гарын үсгээр баталгаажсан байх

3.2 Оролцогчдод тавигдах ерөнхий шаардлага:

- Оролцогч нь оюутны, судлаачийн болон банкны салбарын мэргэжилтнүүдийн аль ангилалд оролцохоо тодорхой бичих (*Монголбанкны ажилтнууд банк санхүүгийн салбарын мэргэжилтний ангилалд оролцох)
- Дотоодын болон гадаадын их дээд сургуулийн бүх оюутнууд оролцож болно.
- Багаар оролцож болно.

3.3 Бичгийн стандарт

- Үсгийн фонт – Times new roman / “Mon” өргөтгөлтэй фонт байж болохгүй/
- Үсгийн фонтын хэмжээ – 12
- Мөр хоорондын зай – 1.5
- Хуудасны хэмжээ: Дээд захаас 20мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм
- Цаасны хэмжээ: А4
- Бүтээлийн хуудасны тоо: Хавсралтгүйгээр 30-с ихгүй байх
- Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй байх

3.4 Эцсийн шатанд шалгарсан бүтээлүүдийн илтгэлд тавигдах ерөнхий шаардлага

- Илтгэлийг PowerPoint эсвэл PDF файлаар хураангуйтай хамт ирүүлэх
- Илтгэл сэдвийн хүрээнд байгаа эсэх
- Шинэлэг санаа агуулсан, олон талт, шинэлэг сэтгэлгээгээр хандсан байх
- Илтгэх чадвар
- Санаагаа тодорхой хүргэж, асуултад оновчтой хариулж буй байдал
- Үгийн сонголт, ярианы чадвар
- Илтгэлийн хугацаа: 10-15 минут

ДӨРӨВ. ХУРЛЫН ҮЕ ШАТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 4.1 Нэгдүгээр шат: Бүтээлийг файл хэлбэрээр хүлээн авч, дүгнэж, дараагийн шатанд шалгарсан оролцогчдод мэдэгдэнэ.
- 4.2 Хоёрдугаар шат: Эхний шатанд шалгарсан судалгааны ажлуудыг 2024 оны 04 дүгээр сард Монголбанкны В байрны 5 давхарт хэлэлцүүлнэ.
- 4.3 Бүтээлүүдийг хэлэлцүүлэхдээ Монголбанкны болон хөндлөнгийн шинжээч нараас бүрдсэн багаар шүүлгэж, дүнг гаргана.

ТАВ. ШАГНАЛЫН САН

5.1 Судлаачийн ангилал

- 1-р байр – Өргөмжлөл, 8,000,000₮ /Найман сая төгрөг/
- 2-р байр – Өргөмжлөл, 5,000,000₮ /Таван сая төгрөг/
- 3-р байр – Өргөмжлөл, 3,000,000₮ /Гурван сая төгрөг/
- 4-р байр – Өргөмжлөл, 1,500,000₮ /Нэг сая таван зуун мянган төгрөг/
- 5-р байр – Өргөмжлөл, 1,000,000₮ /Нэг сая төгрөг/

5.2 Банк, санхүүгийн салбарын мэргэжилтний ангилал

- 1-р байр – Өргөмжлөл, 8,000,000₮ /Найман сая төгрөг/
- 2-р байр – Өргөмжлөл, 5,000,000₮ /Таван сая төгрөг/
- 3-р байр – Өргөмжлөл, 3,000,000₮ /Гурван сая төгрөг/

- 4-р байр – Өргөмжлөл, 1,500,000₮ /Нэг сая таван зуун мянган төгрөг/
- 5-р байр – Өргөмжлөл, 1,000,000₮ /Нэг сая төгрөг/

5.3 Оюутны ангилал

- 1-р байр – Өргөмжлөл, 4,000,000₮ /Дөрвөн сая төгрөг/
- 2-р байр – Өргөмжлөл, 3,000,000₮ / Гурван сая төгрөг/
- 3-р байр – Өргөмжлөл, 2,000,000₮ /Хоёр сая төгрөг/
- 4-р байр – Өргөмжлөл, 1,000,000₮ /Нэг сая төгрөг/
- 5-р байр – Өргөмжлөл, 500,000₮ /Таван зуун мянган төгрөг/

ЗУРГАА. МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ

Хугацаа: 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 16:00 цаг хүртэл бүтээлийг цахим хэлбэрээр erti@mongolbank.mn хаягаар хүлээн авна.

Судалгааны бүтээлийг цахим шуудангаар ирүүлэхдээ оролцогчийн мэдээлэл (нэр, холбоо барих мэдээлэл, цахим шуудан), сургуулийн болон байгууллагын нэр, удирдагч багшийн мэдээлэл болон судалгааны бүтээлийн нэрийг тодорхой бичиж илгээхийг анхаарна уу.

Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанк
Дэлгэрэнгүй мэдээллийг www.mongolbank.mn цахим хуудаснаас
болон (976) 11-323435 утсаар лавлана уу.